



ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК-Н ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

№002/007/20240131-002

2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.31.16 дахь заалтад тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Газар шим үйлдвэр ХК-ийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 4,68 (дөрвөн төгрөг жаран найман мөнгө) мөнгөөр тогтоож, Компанийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 80 (ная) хувийг буюу 5,609,852,000 (таван тэрбум зургаан зуун есөн сая таван зуун наян хоёр мянга) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 02 дугаар сарын 20-ний өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгадамжийн төв” ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор олгосугай.
4. Ногдол ашиг хуваарилж, олгох тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашгийг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгохыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ганбат)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ш.АЛТАНБАГАНА